

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 26 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2026-01

Улаанбаатар хот

2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2025 оны үйл ажиллагааны тайлан ("2025 оны үйл ажиллагааны тайлан")-г хянан хэлэлцээд 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-17 тоот тогтоол гарган, 2025 оны үйл ажиллагааны тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор материаллаг алдаагүй илэрхийлсэн гэж дүгнэж ("ТУЗ-ийн дүгнэлт"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2025 оны үйл ажиллагааны тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 26 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2026-02

Улаанбаатар хот

2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн зөрчилгүй гэж нягтлан баталгаажуулсан Банкны 2025 оны санхүүгийн тайлан ("2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан")-г Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") хянан хэлэлцээд, тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-20 дугаар тогтоолоороо дүгнэн ("ТУЗ-ийн дүгнэлт"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 26 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2026-03

Улаанбаатар хот

Банкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас
ногдол ашиг зарлан хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны 2025 оны цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (“Жилийн эцсийн ногдол ашиг”)-ыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн R-2026-02 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
3. ТУЗ нь 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-20 дугаар тогтоолоор 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг баталсан бөгөөд тус тайлан аливаа материаллаг өөрчлөлтгүйгээр батлагдсан болохыг; мөн
4. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс санал болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Жилийн эцсийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Жилийн эцсийн ногдол ашигт нэгж хувьцаанд 30.00 (гуч) төгрөг зарлан хуваарилсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийг Жилийн эцсийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү тогтоол батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор Жилийн эцсийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд заасны дагуу, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь банкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад

тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



2026 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2026-04

Улаанбаатар хот

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.4 болон 8.6(v) дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-14 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн 2026 оны төсөв ("ТУЗ-ийн 2026 оны төсөв")-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг дурдав.

ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2026-05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд
бүрэн эрх хэрэгжүүлэх Банкны ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, түүний залгамж халааг бэлдэх ерөнхий журмын 2.2.4 дэх заалт, 6.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу, Нэр дэвшүүлэх хороо ("НДХ") нь Банкны хувьцаа эзэмшигчдэд (i) ТУЗ-ийн хараат бус гишүүний дөрвөн (4) орон тоонд таван (5) нэр дэвшигч; (ii) ердийн гишүүний найман (8) орон тоонд хоёр (2) нэр дэвшигчийг нэр дэвшүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдээс ердийн гишүүнд зургаан (6) нэр дэвшигчийг нэр дэвшүүлснийг;
2. Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрх 2 жилийн хугацаатай бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн SR-2024-10 дугаар тогтоолоор сонгогдсон одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа нь Банкны хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал дууссанаар дуусгавар болохыг;
3. ТУЗ 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-42 дугаар тогтоолоор ТУЗ-ийн ердийн гишүүн Албертус Браггинкын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлаар шийдвэрлүүлэхээр тогтоосныг; мөн
4. Хувьцаа эзэмшигчид нь кумулятив аргаар хураасан санал хураалтын үр дүнг тодорхойлсон Тооллогын комиссын шийдвэрт үндэслэн, дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал дуусгавар болох үеэс Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал дуусгавар болох хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгосугай:
 - (i) ТУЗ-ийн хараат бус гишүүний орон тоонд:
 1. Нираж Вэдва;

2. Эрэндоогийн Оюунбилэг;
3. Стюарт Доналд Холл; мөн
4. Эми Чой (Лай Фунг Чой).

(ii) ТУЗ-ийн ердийн гишүүний орон тоонд:

1. Нямтайширын Цэлмүүн;
2. Санжай Гүпта;
3. Гүмэнжавын Цэвэгжав;
4. Сюзанна Карр;
5. Ашот Осипян;
6. Майкл Мадден;
7. Мелисса Мой Тиен; мөн
8. Баатарын Батсайхан.

2. Хувьцаа эзэмшигчид Албертус Браггинкын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр хүлээн авсанд тооцсугай.
3. Одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацааг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал дуусгавар болох үеэс дууссанд тооцсугай.
4. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлж, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай эсхүл зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгаж, холбогдох эрхийг олгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА